

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 дугаар
сарын 26-ны өдөр

№ 01/23

Улаанбаатар хот

Хурлын ирцийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Эм Эн Ди” ХК-ийн нийт 97,360 саналын эрхтэй энгийн хувьцааны 72,265 хувийг эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч оролцсон учир хурлыг хүчин төгөлдөрт тооцох саналын хувь бүрдсэн гэж үзэн хурлыг хүчинтэйд тооцсугай.

Хурлын ирц хангалтай тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИСС:

КОМИССЫН ДАРГА:



Б.СҮНЧИГМАА

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 дугаар
сарын 26-ны өдөр

№ 02/23

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Эм Эн Ди” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Эм Эн Ди” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг сунгасугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр:

1. Намсрайн Отгон-Од
2. Пионг Чунг Фах (Piong Choong Fah)
3. Чунг Чии Иенн (Chung Chee Yenn)
4. Лю Вен Тейк (Lew Wen Teik)
5. Н.Ганчимэг
6. Н.Гансувд

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Ц.Болд
2. Н.Ганбаатар
3. Б.Сарнай

“2. Эм Эн Ди” ХК-ийн хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд:

1. “ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.

1. Гансувд /Дарга/ 2. Отгон-од 3. Сарнай

2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.

1. Болд /Дарга/ 2.Отгон-Од 3.Гансувд

3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.

1. Отгон-Од 2.Ганбаатар 3.Сарнай

Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Н.ГАНЧИМЭГ/

“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 дугаар
сарын 26-ны өдөр

№ 03/23

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн талаархи
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
хараат бус аудитын дүгнэлтийг батлах
тухай*

“ЭМ ЭН ДИ” Хувьцаат компанийн 2022 оны жилийн үйл ажиллганы болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцэн баталж, Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, 46 дугаар зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаархи хангалттай гэж үзсүэй.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Н.ГАНЧИМЭГ/

“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 дугаар
сарын 26-ны өдөр

№ 04/23

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын бүрэн эрх,
цалин урамшуулал

Компанийн тухай хуулийн 62 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Тус компанийн Гүйцэтгэх захирал Намсрайн Отгон-Од-ын бүрэн эрхийг сунгаж,
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу цалин урамшууллыг тооцон
олгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Н.ГАНЧИМЭГ/